МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА”

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	**БГСТ-25/003**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Э.Цолмончимэг LL.M

Улаанбаатар хот
2025 он

ГАРЧИГ

1. Удиртгал хэсэг
   1.1. Судалгааны арга зүй, аргачлал
   1.2. Судлагдсан байдал
   1.3. Судалгааны хамрах хүрээ

2. Мөнгө хүүлэлттэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалтын онцлог
   2.1. Олон улс дахь мөнгө хүүлэлтийн эрх зүйн ойлголт, хуульчлагдсан байдал
   2.2. Олон улс дахь мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай зохицуулалтын нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөө

3. Мөнгө хүүлэлттэй тэмцэх талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

4. Гадаадын зарим улс, орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалтын онцлог
   4.1. Америкийн Нэгдсэн Улс
   4.2. Европын холбооны улсууд
   4.3. Япон улс

5. Дүгнэлт, санал
6. Эх сурвалж/Ном зүй

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол Улсын хувьд банк, зээлийн үйл ажиллагаа явуулж буй эрх бүхий этгээдүүдээс хэрэглэгч, зээлдэгч нарт олгох зээлийн хүүгийн хэмжээнд аливаа хязгаарлалт тавьдаггүй бөгөөд зээлийн хүүгийн хэмжээнд хязгаарлалт тавихад чиглэсэн аливаа эрх зүйн орчныг бүрдүүлээгүй байна. Энэ талаар хуулийн зохицуулалт шаардлагатай байгаа тухай дурдаж, 2018 онд Улсын Их Хурлын Гишүүн С.Эрдэнэ "*Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль*"-ийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьж байсан боловч Эдийн засгийн Байнгын хороогоор дэмжигдээгүй байна. Тус хуулийн зорилго нь банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэж байв.[1] Тухайн үед энэхүү хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад байнгын хорооны гишүүдийн зүгээс "*Монгол Улсын хувьд эдийн засаг нь гадаад зах зээлээс хамааралтай, санхүүгийн сахилга бат сул, гадаад валютын нөөц, ханшийн тогтвортой байдал хангалтгүй байгаа энэ үед захиргааны аргаар зээлийн хүүг бууруулах нь эрсдэл өндөртэй байна. Эдийн засгийн макро орчныг тогтворжуулах, арилжааны банкнуудын засаглалыг сайжруулах, банк, санхүүгийн байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай. Зээлийн хүүг бууруулдаг захиргааны болон эдийн засгийн хоёр аргыг хослуулан бууруулах нь эерэг үр дүнд хүрнэ"*[2] гэсэн саналуудыг гаргаж байжээ.

Энэхүү хуулийн төсөл өргөн баригдсантай холбоотойгоор Монголбанкны зүгээс "*Монгол Улсын хувьд зээлийн хүүг бууруулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, мөнгө хүүлэлтийг зогсоох, иргэд хоорондын богино хугацаатай, өндөр хүүтэй зээлийн харилааг зохицуулах бодит шаардлага байгаа боловч банкны салбарт захиргаадалтын аргаар хүү хязгаарлах оролдлого нь зах зээл, эдийн засагт нэмэлт гажуудлыг бий болгох эрсдэлтэй тул тогтвортой хэрэгжих боломжгүй. Ялангуяа макро эдийн засгийн болон санхүүгийн зах зээлийн тогтвортой орчин бүрэн бүрэлдээгүй өнөө үед зээлийн хүүг захиргаадалтын аргаар бууруулах оролдлого нь санхүүгийн зуучлалыг зогсоож, хөрөнгийн зугталтыг бий болгож, санхүүгийн хүртээмжийг хумьж, эдийн засгийг хүндрэл рүү хөтлөх эрсдэл өндөр*"[3] гэсэн зөвлөмжийг гаргаж байжээ.

Хэдийгээр Монгол Улсын хувьд банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос олгох зээлийн хүүгийн хэмжээ өндөр бөгөөд энэхүү зээлийн хүүгийн хэмжээг тодорхой түвшинд хязгаарлахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлээгүй байгаа хэдий ч энэхүү асуудлыг хуульд оновчтой тусгаж зохицуулахгүй тохиолдолд олон сөрөг үр дагаварт хүргэх боломжтойг Монголбанкнаас тэмдэглэсээр ирсэн байна. Тэр дундаа банкны салбарт захиргаадалтын аргаар хүүгийн дээд хэмжээ тогтоох нь мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах, төв банкны зорилтоо хангах боломжийг хязгаарлах, төв банкны бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлнө[4] гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Иймхүү, Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын талаар гаргасан судалгааны тайлангаас харахад банкны салбарын нийт активын хэмжээ 2008 онд ДНБ-ний

---

[1] Эрдэнэ.С. *Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэллтэй тэмцэх тухай хуулийн төсөл.* 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр. https://forum.parliament.mn/projects/295 Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

[2] Эдийн засгийн байнгын хороо. *Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл бариmтлал, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаархи санал, дүгнэлт.* 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр. file:///C:/Users/Owner/Downloads/%D0%B7%D1%8D%D1%8D%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%85%D2%AF%D2%AF-%D1%85%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB%D1%86%D1%8D%D1%85%20%D1%8D%D1%81%D1%8D%D1%85%20(3).pdf Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

[3] Монголбанк. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэнцэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монголбанкнаас гаргасан зөвлөмж. //,* Мөнгө, санүү, баялаг сэтгүүл, (2019, №14), 8 дахь тал

[4] Монголбанк. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэнцэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монголбанкнаас гаргасан зөвлөмж. //,* Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, (2019, №14), 10 дахь тал

56 хувьтай тэнцэж байсан бол 2019 онд 97 хувь болж нэмэгдсэн байна. Түүнчлэн, банкны салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувь нь харьцангуй өндөр буюу 2019 оны байдлаар 90 орчим хувь бөгөөд үүнээс шалтгаалан иргэд болон хувийн салбар санхүүжилтийн хэрэгцээгээ банкны зээлээр голлон бүрдүүлж байгаа[5] тухай тусгасан нь банкны зээл нь манай улсын хувьд маш чухал санхүүгийн хэрэгслийн нэг болохыг харуулж байна. Түүнчлэн, Монголбанкнаас бодлогын хүүг 2024 оны 09 дүгээр сарын байдлаар инфляцийн түвшинтэй уялдуулан 10 хувь болгон бууруулсан хэдий ч зээлийн хүү тогтмол өндөр түвшинд хадгалагдсаар байгаа[6] тухай тус тус дурджээ.

Энэ нь манай улс банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлийн хүүг тодорхой түвшинд хязгаарлах, зохистой тогтоох талаар эрх зүйн зохицуулалтгүй бөгөөд зөвхөн эдгээр зээл олгох эрх бүхий этгээдүүдийн салбарын хууль тогтоомж буюу зээл олгогчдын эрх ашгийг илэрхийлсэн хууль эрх зүйн орчинтой байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

Иймд энэхүү судалгааны хүрээнд зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоосон гадаад улс орнуудын туршлагыг судлах, манай улсын хувьд тус эрх зүйн орчны зохицуулалтыг оновчтой нутагшуулах арга замыг эрэлхийлсэн болно.

1.1.Судалгааны арга зүй, аргачлал

Энэхүү судалгааны ажлын хүрээнд харьцуулсан судалгааны арга, баримт бичгийн шинжилгээний арга, анализ хийх зэрэг судалгааны аргыг ашигласан болно.

1.2.Судлагдсан байдал

Мөнгө хүүлэлт нь аливаа улсын нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж, хэт өндөр хүүтэй зээл олголтын улмаас хэрэглэгч, зээлдэгчийн эрх ашиг ноцтой зөрчигдөж буй асуудал нь дэлхий дахины хэмжээнд заавал хуулиар зохицуулагдах шаардлагатай асуудлуудын тоонд зүй ёсоор багтаж байна. Энэ утгаараа энэхүү судалгааны сэдэв нь Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан болон бусад олон улсын байгууллагууд, бүс нутгийн болон үндэсний хүрээнд өргөн судлагдсан байх боловч манай улсын хувьд хангалттай хэмжээнд судлагдаагүй байна.

1.3.Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлийн хүүгийн хувь хэмжээг тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй зарим гадаад улс орнуудын эрх зүйн туршлагыг судалж, Монгол Улсын хувьд авч хэрэгжүүлж болох үр ашигтай арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргахад чиглэсэн болно. Ингэхдээ, энэхүү судалгаанд гадаадын зарим улс орнуудын мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалтуудын онцлог, тэдгээрийг хуульчилсан байдлыг харьцуулан судалсан болно.

[5] Дэлхийн банк *Монголын эдийн засгийн тойм. Эдийн засгийн тогтвортой байдал, банкны зээлийн өсөлт.* 2020 оны 1 дүгээр сар. https://documents1.worldbank.org/curated/zh/990641581913444305/pdf/Mongolia-Economic-Update-Macroeconomic-Stability-and-Credit-Growth.pdf Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

[6] Дэлхийн банк *Монголын эдийн засгийн тойм.* 2024 оны 11 дүгээр сар. https://documents1.worldbank.org/curated/en/099533111272490277/pdf/IDU17bc4d9961fbf71470b19731126d994aab926.pdf Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

II. МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

2.1. Олон улс дахь мөнгө хүүлэлтийн тухай эрх зүйн ойлголт, хуульчлагдсан байдал

Улс орон бүр “мөнгө хүүлэх” гэсэн нэр томьёог харилцан адилгүй байдлаар тодорхойлж, хуульчилсан байх боловч нийтлэг ойлголтын хүрээнд энэхүү ойлголт нь хэрэглэгчийн сул тал, мэдлэг боловсрол дутмаг байдлыг санаатайгаар урвуулан ашиглаж, өндөр ашиг олох зорилгоор үндэслэлгүй хэт өндөр зээлийн хүү тогтооход чиглэсэн үйлдэл хэмээн ойлгож байна. Олон улсын хэмжээнд мөнгө хүүлэхтэй тэмцэх тухай хуулийг anti-usury (хууль бусаар өндөр хүүтэйгээр мөнгө зээлэхийг хориглох тухай хууль)[7] хэмээн томьёолж байгаа бөгөөд энэ хууль нь хэрэглэгчдийг хэт өндөр зээлийн хүүнээс хамгаалах болон тэдэнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг байна.

Дэлхийн банкнаас гаргасан судалгааны тайлангаас үзэхэд дэлхийн 76 улс орон зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон тухай дурдсан байна. Ийнхүү зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болсон үндсэн шалтгаанууд нь хэт өндөр зээлийн хүүнээс хэрэглэгчдийг хамгаалах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон зээл авах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Испани улс болон ихэнх улс орнуудын хувьд голчлон хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалахад чиглэсэн зохицуулалттай бол бусад улс орны хувьд илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгажээ. Тухайлбал, Португал улсын хувьд эмзэг бүлгийг хамгаалах; Бельги, Франц, Бүгд Найрамдах Киргиз, Польш, Бүгд Найрамдах Словак улс болон Их Британи улсуудын хувьд хэрэглэгчдийг зохисгүй зээлийн үйл ажиллагаа болон хэт өндөр хүүгийн хэмжээнээс хамгаалах; Грек улсын хувьд хэт их эрх мэдлээс үүдэлтэйгээр эрх хэмжээгээ хэтрүүлэн ашиглах явдлыг хязгаарлах; Эстони улсын хувьд хэт их өрийн дарамтаас сэргийлэх; Нидерланд улсын хувьд зээл олгогчдын чанаргүй зээл олголтыг бууруулахад чиглэсэн байна. Түүнчлэн, Тайланд улсын эрх бүхий байгууллагаас зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон нь бага орлоготой зээлдэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ хэмээн тэмдэглэжээ. Харин Замби улсын хувьд хэт их өрийн дарамтаас үүсэх эрсдэлийг бууруулах, зээлийн өндөр зардлыг бууруулах болон хязгаарлагдмал үйлчилгээ авч буй иргэдэд зээл олголтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.[8]

Харин Олон Улсын Санхүүгийн Байгууллагын гишүүн орнуудын мөнгө хүүлэлтийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд зээлийн хүүгийн хувь хэмжээг зах зээлийн хүчин зүйлээс шууд шалтгаалан харин төв банкнаас тогтоосон бодлогын хүүгийн хэмжээнээс шууд бусаар шалтгаалан тогтдог байхаар зохицуулж байна. Харин Европын холбооны улсуудын хувьд хүүгийн хэмжээ тогтоох бодлогыг Европын Төв Банкны Удирдлагын Зөвлөлөөс тодорхойлдог. Түүнчлэн, Филиппин улсын хувьд 1980-аад оны дунд үеэс эхлэн төв банкнаас хүүгийн хувь хэмжээг тогтоохдоо тодорхой зах зээлтэй нь уялдуулан тогтоох бодлогыг авч хэрэгжүүлж байна.[9]

Үүнээс харахад, олон улс дахь мөнгө хүүлэлтийн эрх зүйн зохицуулалт нь зөвхөн зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтооход чиглэсэн гэхээс илүү тухайн салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг нийгэм, эдийн засгийн нөлөө бүхий цогц асуудал байна.

---

[7] Garner, B.A.(Ed). (2014). *Black’s law dictionary* (10th ed.). ///. United States of America: Thompson Reuters. P.1778
[8] World Bank Group, (2014). *Interest Rate Caps around the World.* https://documents1.worldbank.org/curated/en/876751468149083943/pdf/WPS7070.pdf Last visited on 6 February 2025
[9] IFC Secretariat. (2022). *Guidance note 2 – Interest Rate Policy and Anti-Usury Regulations.* https://www.bis.org/ifc/interest_rate_policy.pdf Last visited on 6 February 2025

Иймд олон улсын түвшинд санхүүгийн хэрэглэгчдийг хэрхэн хамгаалж байгаа талаар, G-20-ийн улсуудаас жишээ аван дурдахад, эдгээр улсуудаас “санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтын өндөр түвшний зарчмууд”-ыг гаргасан бөгөөд дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Эрх зүй, зохицуулалтын болон хяналт шалгалтын хамрах хүрээ
2. Хяналт шалгалтын байгууллагуудын үүрэг, ач холбогдол
3. Хэрэглэгчдэд эн тэнцүү, шударга хандах
4. Тайлагнал, ил тод байдал
5. Санхүүгийн боловсрол ба түүний сурталчилгаа
6. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн болон эрх бүхий агентуудын бизнесийн хариуцлагатай байдлын кодекс
7. Санхүүгийн хэрэглэгчдийн хөрөнгийг буруу ашиглах, хууран мэхлэх шамшигдуулахаас хамгаалах
8. Санхүүгийн хэрэглэгчийн мэдээлэл, хувийн нууцлалыг хамгаалах
9. Өргөдөл гомдлыг авч хэлэлцэх, барагдуулах
10. Өрсөлдөөн

Харин дэлхийн 108 улсын хувьд энэ асуудлыг авч үзвэл 2013 оны байдлаар:

- Санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтын зохицуулалт бүхий 103 улс байна.
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ерөнхий хуулийн орчинтой 70 улс байна.
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуульдаа санхүүгийн үйлчилгээтэй холбоотой зүйл заалтуудыг оруулсан эсвэл санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан хуультай 58 улс байна гэсэн байна.[10]

2.2. Олон улс дахь мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай зохицуулалтын нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөө

Зээлийн хүүг тогтоож буй аргачлалын хувьд 24 улсад үнэмлэхүй дээд хязгаар буюу тогтмол нэрлэсэн хувь хэмжээ (absolute ceilings)-г тогтоосон бол 32 улсад харьцангуй хязгаартай (relative ceilings) хүүгийн дээд хэмжээг зах зээлийн дундаж хүү, эсхүл хүүгийн суурь түвшин зэрэг хувьсах хэмжигдэхүүнтэй уялдуулан тогтоосон байна. Ийнхүү хүүгийн дээд хэмжээг тогтоосон дийлэнх улс орнуудын хувьд хүүгийн дээд хэмжээг зээлийн дүн, төрөл, хугацаа зэргээс хамааран ялгаатай байдлаар тогтоож байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосноор зарим улсад сөрөг үр дагавар ажиглагдаж байгаа гэж холбогдох судалгааны тайлангуудад дурджээ. Тухайлбал:

- Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын хувьд зарим санхүүгийн байгууллагууд нь зээлдэгчийн амь насны даатгал, болон бусад үйлчилгээгээр дамжуулан зээлийн нийт өртгийг тооцох, ил тод байдлыг хангах боломжийг бууруулсан;

- Баруун Африкийн Эдийн засаг, мөнгөний холбооны гишүүн улс орнуудын хувьд бичил санхүүгийн зээлд зээлийн хүүгийн дээд хэмжээг доогуур тогтоосноос болж буурай, алслагдмал бүсийн бичил санхүүгийн байгууллагууд уг сигментээс гарах, санхүүгийн байгууллагууд нь эргэлтээ нэмэгдүүлэх зорилгоор зээлийн дундаж хэмжээгээ нэмэгдүүлэх болсон;

- Америкийн Нэгдсэн Улсад зээлийн хүүгийн дээд хэмжээг доогуур тогтоосноос зээл олголт буурч, улмаар хууль бус зээлийн үйл ажиллагаа нэмэгдэх болсон;

[10] Монголбанк. *Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд.* 25-26 дахь тал

- Боливи Улсад 2004 онд зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосноор шинээр байгуулагдах санхүүгийн байгууллагын тоо цөөрсөн;

- Армен, Никарагуа болон Өмнөд Африк зэрэг улсуудад зээлийн хүүг тооцох аргачлалыг нарийвчлан тогтоогоогүйгээс нэмэлт шимтгэл, хураамж хэлбэрээр зээлийн өртгийг нэмэгдүүлж, ил тод байдлыг бууруулсан;

- Франц болон Герман улсуудад орлого багатай иргэдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүний төрөл багасгах хандлагатай болсон;

- Харин Америкийн Нэгдсэн Улсад хүүгийн дээд хэмжээг тогтоосноор хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хүү буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж тус тус дүгнэжээ.[11]

Мөн холбогдох судалгааны тайлангаас харахад мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь улс орнуудын нийгэм, эдийн засагт дараах эерэг болон сөрөг үр дагавар авчирч байгаа нь ажиглагдаж байна.

Эерэг нөлөө:

- *<u>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах:</u>* Мөнгө хүүлэлттэй тэмцэх нь санхүүгийн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зорилготой. Мөнгө хүүлэлт, өндөр хүүтэй зээлийн нөхцөл нь иргэдийг санхүүгийн дарамтанд оруулах бөгөөд мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь энэ хүндрэлийг бууруулж, хүмүүст зөв зохистой зээлийн үйлчилгээ авах боломжийг олгодог.

- *<u>Эдийн засгийн тогтвортой байдал:</u>* Мөнгө хүүлэлттэй тэмцэх нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Зээлийн хүү хэт өндөр түвшинд байснаар иргэд, бизнесүүд нь санхүүгийн тогтвортой байдлаа алдах аюултай байдаг тул мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг.

- *<u>Санхүүгийн ил тод байдал:</u>* Мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг ил тод байдалд орж, үйл ажиллагаагаа илүү хариуцлагатай явуулахад түлхэц өгдөг. Энэ нь хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлж, зээлийн системийн шударга байдлыг хангахад тусалдаг.

- *<u>Хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх:</u>* Мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь хэрэглэгчдэд санхүүгийн боловсрол олгоход чухал нөлөө үзүүлдэг. Иргэд илүү зөв ойлголттой болж, зээл авах үедээ мэдээллээр хангагдаж, зөв шийдвэр гаргахад тусалдаг.

Сөрөг нөлөө:

- *<u>Банк, санхүүгийн байгууллагуудын орлого буурах:</u>* Мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь банк, санхүүгийн байгууллагуудын зээлийн хүүг бууруулахад хүргэдэг бөгөөд энэ нь тэдний орлогыг багасгаж, санхүүгийн салбарыг бага орлоготой болгох аюултай. Үүний улмаас зарим байгууллагууд үйл ажиллагаагаа хязгаарлах, өрсөлдөөн багасах гэх мэт сөрөг үр дагавартай байж болох юм.

[11] Улсын Их Хурлын Тамгын Газар. *Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин.* 2017 он. 3 дахь тал

- *<u>Зээлийн хүртээмж буурах:</u>* Хүүгийн хязгаарлалттай зохицуулалт нь санхүүгийн байгууллагуудыг өндөр эрсдэлтэй зээл олгох хүсэлгүй болгож, зарим иргэдэд зээл олгох боломжийг хязгаарлах магадлалтай. Энэ нь зарим бүлэг хүмүүсийг санхүүгийн үйлчилгээ авахаас орхигдуулж болзошгүй.

- *<u>Албан бус санхүүгийн байгууллагуудын өсөлт:</u>* Мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалт нь банкны хүүг бууруулахад хүрвэл албан бус, хууль бус санхүүгийн байгууллагууд (жишээ нь, хувь хүн, жижиг зээл олгох компаниуд)-ын эрэлт нэмэгдэх магадлалтай. Эдгээр байгууллагууд нь хэрэглэгчдийн эрхийг зөрчих, өндөр хүүтэй зээл өгөх зэрэг эрсдэлтэй байдлыг бий болгож болно.

- *<u>Эдийн засгийн хямралтай үед байгууллагуудын хязгаарлалт:</u>* Хүнд хямралтай үед санхүүгийн байгууллагууд нь өндөр эрсдэлтэй зээл олгох, эсвэл зөвшөөрөгдсөн хүүгийн хязгаарлалт давах зэрэг асуудалтай тулгарч, зээл олголтын хэмжээ багасаж, эдийн засгийн өсөлт буурах боломжтой байдал үүсч болзошгүй.

III. МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Мөнгө хүүлэлтийн эрх зүйн ойлголтын хувьд Монгол Улсын Иргэний хуульд тодорхой зохицуулалт байхгүй ч “нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээ”-ний талаар Улсын Дээд шүүхээс тайлбарласан байна.[12] Тухайлбал, Иргэний хуулийн 56-р зүйлээр хэлцэл хүчин төгөлдөр бус байх тухай заасан бөгөөд 56.1.1-д “*хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл*” гэсэн зүйлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ гэсэн ойлголт одоо маш чухал болж байна. Учир нь зээлийн хүү хэт өндөр байх, энэ нь тухайн зээл олгогч институциудийн зах зээл дээрх олигополь байдал, давуу талаас үүсэн гарсан зээлийн гэрээний талуудын эрх чөлөө, эрх тэгш, шударга байх зарчмыг зөрчсөн, зээлдэгч талын санхүүгийн (зээлийн) хэрэгцээний аргагүйдсэн, зайлшгүй байдлыг ашигласан, түүн дээр түшиглэж зээлийн хүү, нөхцөлүүдийг “тулгасан” зээлдэгчийн хүсэл зоригийн илэрхийлэл зээлийн гэрээнд тусгагдаагүй байх, санхүүгийн секторт шударга өрсөлдөөн сул, санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт байхгүй орчинд зээлийн хэт өндөр хүү, мөнгө хүүлэлтийн шинжтэй санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь нийгмийн зан суртахуун талаас нь авч үзвэл “*нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан*” үйл ажиллагаанууд юм. Чухам тиймээс л зээлийн хүүний хязгаарлалт, мөнгө хүүлэлтийг хориглосон, хязгаарлалт тогтоосон барууны эрх зүйн тогтолцоонд “good moral” – “сайн зан суртахуун”- ны зарчмыг хууль тогтоомжид түүхэн байдлаар, зуун дамжин хэрэглэж ирсэн эрх зүйн орчин уламжлан оршсоор иржээ.

Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тогтоолд “*нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн гэдэгт эрх, үүрэг тодорхой хэмжээгээр бий болгон уламжлагдан хэрэглэгдэж байгаа, нийтээр дагаж мөрдөн дадал хэвшил болсон зан заншил, ёс суртахууны хэм хэмжээ*” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын хувьд ч энэ “сайн зан суртахууны” эрх зүйн зааltууд Иргэний хуулийн тодорхой бүлэг, дэд бүлэгт туссан байгаа бөгөөд түүхэн талаасаа, шашны сургаал, уламжлал талаасаа ч үзсэн Монгол Улсад байсан, байгаа гэж үзэх үндэслэлүүд байдаг. Монгол Улсын Иргэний хуульд “*нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд харшилсан*” гэсэн ойлголтын хүрээнд авч үздэг, энэ нь барууны эрх зүйн тогтолцооны чухал ойлголт

[12] Монголбанк.*Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд.* 3 дахь тал

болох “good moral” – сайн зан суртахууны ойлголттой ижил агуулгатай ба мөнгө хүүлэх үйл ажиллагаанд шууд хамааралтай гэж дүгнэж болно.[13]

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хууль тогтоомжид мөнгө хүүлэлтийн тухай эрх зүйн ойлголтыг тухайлан бие даасан хуулиар зохицуулаагүй хэдий ч иргэний эрх зүйн харилцааны суурь ойлголт болох “хэлцэл”-ийн тухай ойлголтод хамааруулан авч үзсэн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын хувьд хэрэглэгчдийн зээл олгох байгууллагаас авсан зээлийн төрлийг дараах байдлаар ангилан судалсан байдаг. Үүнд:

Зээлийн төрөл	**Хувь, хэмжээ**
Ипотекийн зээл	25.5
Банкны зээл	45.3
ББСБ-ын зээл	20.4
Цахим зээл	25.6
Хувь хүмүүсээс авсан зээл	34.2
Барьцаалан зээлдүүлэх газар болон өдрийн зээлийн үйлчилгээ	26.1

Хүснэгт 1. Иргэдийн зээл олгогч байгууллагаас авсан зээлийн төрөл[14]

Дээрх хүснэгтэд хувь хүмүүсээс авсан зээл, барьцаалан зээлдүүлэх газар болон өдрийн зээлийн үйлчилгээний хувь хэмжээ өндөр байгаа нь тэдний зээл олгоход тавих шаардлага нь банк, банк бус санхүүгийн байгууллагуудаас хялбар болохыг илтгэнэ. Ийм учраас зээлийн хүртээмж бага, ажилгүй, тогтмол орлогогүй, тэтгэвэрт гарсан, оюутан гэх мэт иргэдэд эрэлт хэрэгцээтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ болж байна. Монгол Улсын санхүүгийн салбарт зээлийн үйлчилгээг арилжааны банк, ББСБ, ХЗХ болон барьцаалан зээлдүүлэх газрууд үзүүлж байна.[15]

(i) Банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооноос олгож буй зээлийн хувьд

Банкны системийн нийт актив 2023 оны I улиралд 451.0 тэрбум төгрөгөөр өсөж, 46,402.5 тэрбум төгрөгт хүрсэн. Активын өөрчлөлтийг данс тус бүрээр харвал гадаад актив 1,162.3 тэрбум, дотоодын цэвэр зээл 875.1 тэрбум төгрөгөөр өссөн, банкны нөөц 939.5 тэрбум төгрөг, ТБҮЦ 567.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2023 оны I улирлын эцсийн байдлаар нийт активын 45.6 хувийг дотоодын цэвэр зээл бүрдүүлж байгаа нь өмнөх улирлаас 1.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эхний улирлын байдлаар 23.2 их наяд төгрөг болжээ. Үүний 54.0 хувийг иргэдийн зээл эзэлж байна. Түүнчлэн, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар шинээр олгосон нийт зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 16.1 хувьтай байна. Шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсөж жилийн 16.7 хувьд хүрчээ.[16]

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 514 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн нийт хөрөнгө 3.7 их наяд төгрөг ба 1,297.0 мянган зээлдэгчдийн зээлийн үлдэгдэл 2.9 их наяд төгрөг байна. ББСБ-уудын нийт зээлдэгчдийн тоо 1,297.0 мянга ба нэг зээлдэгчид

[13] Монголбанк.*Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд.* 19-20 дахь тал

[14] *Монголбанк. Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа. 2022 он*

[15] Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он.

[16] Мөн тэнд.

ногдох дундаж зээлийн хэмжээ 2.2 сая төгрөг байна. ББСБ-уудын зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь 8.0 буюу 228.0 тэрбум төгрөгт хүрсэн. Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 3.1 хувь байна.[17]

Хадгаламж зээлийн хоршооны хувьд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 191 хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/ 69,962 гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр хадгаламж зээлийн хоршоодын нийт хөрөнгө 274.5 тэрбум төгрөг болно. Хадгаламж зээлийн хоршооны салбарын хэмжээнд 31,248 зээлдэгчийн 212.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 0.38 пунктээр буурсан үзүүлэлтэй. ХЗХоос олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.3 хувь байна.[18]

Ийнхүү Монгол Улсын хувьд зээлийн хүү тогтмол өндөр түвшинд байгаа бөгөөд банкны зээл нь иргэдийн хувийн хэрэглээгээ бүрдүүлж буй томоохон эх үүсвэрийн нэгт тооцогдож байгаа энэ үед хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хэрэгцээ, шаардлага тулгараад байгаа билээ.

Энэ талаар Монголбанкнаас манай орон зээлийн хүүг бууруулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө хүүлэлтийг зогсоох, иргэд хоорондын богино хугацаатай, өндөр хүүтэй зээлийн харилцааг зохицуулах бодит шаардлага байна[19] хэмээн мэдээллэсэн байна. Түүнчлэн, Монгол Улс нь бага орлоготой бусад улсуудтай харьцуулахад зээлийн хүүний түвшин бага, дундаас доогуур орлоготой улс орнуудтой харьцуулахад 5 нэгж хувиар өндөр, бус нутаг буюу Зүүн Ази, Номхон далайн орнуудтай харьцуулахад 10 нэгж хувиар өндөр байна[20] хэмээн судлаач Г.Батзориг дурджээ.

(ii) Барьцаалан зээлдүүлэх газраас олгох зээл болон иргэд хоорондын ашиг олох зорилготой зээлийн үйл ажиллагаа

Уламжлалт банкны үйлчилгээ авах боломжгүй иргэдийн хувьд барьцаалан зээлдүүлэх газрууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд хувийн эд зүйлсийг барьцаанд авч, үнэлэгдсэн үнээр нь зээл олгодог. Барьцаалан зээлдүүлэх газар, зээлийн үйлчилгээг тойрсон нэг анхаарал татахуйц асуудал бол эдгээр зээлээс ихэвчлэн өндөр хүү авч байна[21] хэмээн Санхүүгийн зохицуулах хорооноос тэмдэглэсэн байна.

Иймд, манай улс 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Тус хуулийн 4 дүгээр хэсэгт мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээд эрхэлнэ.

---

[17] Мөн тэнд.

[18] Мөн тэнд.

[19] Монголбанк. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэнцэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монголбанкнаас гаргасан зөвлөмж. //,* Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, (2019, №14), 1 дэх тал

[20] Батзориг.Г. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох нь боловсон цэвэрлэгээ гэж үү?*. //, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, (2019, №15), 115 дахь тал

[21] Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он. https://www.frc.mn/resources/Images/Document/202311/WIxlY/%D0%A1%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0.pdf Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

- Байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу эрх бүхий этгээдэд бүртгүүлсний үндсэн дээр Монгол Улсын иргэн эрхэлж болно хэмээн тус тус зохицуулжээ.

Түүнчлэн тус хуульд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг зохицуулж, бүртгэх замаар хяналтын механизмд оруулж, зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосноор мөнгө хүүлэлтийг хязгаарлах, хяналт тавих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн үндсийг тогтоожээ.

Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх орон тооны бус Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлахаар хуульчилсан байна.

Ийнхүү 2024 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 1 дугаартай тогтоолоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь байхаар тогтоосон байна. Энэ нь Монгол Улсын хувьд иргэд хоорондын болон барьцаалан зээлдүүлэх газраас үндэслэлгүйгээр өндөр хүүтэй мөнгө зээлдэх явдлыг хязгаарлаж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үр ашигтай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн хууль болжээ. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү хуулийн үйлчлэл нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос олгох зээлийн үйл ажиллагаанд хамааралгүй юм.

Гэтэл банкны зээлийн хүү нь эх үүсвэрийн хүү болон хүүний зөрүүгийн нийлбэрээр тодорхойлогддог бөгөөд банкны зээлийн хүү өндөр байгаа нь банкны хадгаламжийн хүү өндөр байгаатай шууд холбоотой байна. Харин зарим санхүүгийн байгууллагуудын хувьд хүүний зөрүүнд харгалзах зардлууд тодорхой бус бөгөөд эх үүсвэрийн хувьд хадгаламжаас бүрддэггүй, эх үүсвэр тодорхойгүй эсхүл эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөс бүрдүүлснээс шалтгаалан зээлийн хүү нь үндэслэлгүйгээр өндрөөр тогтож байхыг үгүйсгэхгүй талаар Монголбанкнаас тэмдэглэсэн байна.[22]

Иймд, манай улсын хувьд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлийн хүүний хэмжээг зохицуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн хэрэглэгчдийг тодорхойлж, тэдгээрийг хамгаалах хамгаалалтын механизмыг оновчтой тодорхойлох хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байна.

IV. ГАДААДЫН ЗАРИМ УЛС, ОРНЫ МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

4.1.Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ийн Холбооны хуульд мөнгө хүүлэлтийн эсрэг ерөнхийлөн зохицуулсан хууль байхгүй боловч зарим эрх зүйн зохицуулалт шаардлагатай хэсгийг тухайлан зохицуулсан байдаг. Тухайлбал, 1980 оноос өмнө Ипотекийн зээлийн дээд хэмжээг 5% байхаар тогтоосон байдаг. Мөн 1970 оноос эхлэн зээлийн хүүгийн хэмжээ ихсэж хүмүүст дарамт үүсэж байсан тул 1983 оноос эхлэн зээлийн хүүгийн хэмжээг хязгаарлаж эхэлсэн байдаг.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд одоогийн байдлаар 4 өөр төрлийн мөнгө хүүлэлтийн эсрэг Холбооны хууль нь одоог хүртэл хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна. Үүнд:

[22] Монголбанк. *Зээлийн хүүний дээд хязгаар, мөнгө хүүлэлттэй холбоотой асуудлууд.* 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр. https://www.mongolbank.mn/file/c68806ba768a857da646f24c9a6dbdf9/files/20181116_01.pdf Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хандсан

Нэгдүгээрт, National Bank Act (Үндэсний Банкны тухай хууль)-аар 90 хоногийн хугацаатай өрийн бичиг (commercial paper) хөнгөлөлтийг 1% байхаар тогтоосон байна.

Хоёрдугаарт, 1980 онд баталсан Federal Deposit Insurance Act (Холбооны Мөнгөн Хадгаламжийн Даатгалын тухай хууль) нь National Bank Act хуультай холбоотой эрх зүйн зохицуулалт бөгөөд мужаас үйл ажиллагааг нь зохицуулдаг банкийг даатгалд хамруулах тухай тусгасан байна.

Гуравдугаарт, National Credit Union Administration Act (Үндэсний Зээлдүүлэгчийн Холбооны Зохицуулалтын тухай хууль)-ийн дагуу Холбооны зээлийн хүүгийн дээд хэмжээ нь жилийн 15% байхаар 1980 оноос хойш зохицуулж байсан бол 2010 оноос жилийн зээлийн хүүгийн дээд хэмжээг 28%-иас хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.

Дөрөвдүгээрт, 2006 онд АНУ-ийн Конгресс нь Military Lending Act (Цэргийн Алба Хаагчийн Зээлийн тухай хууль) баталсан байна. Энэхүү хуулиар цэргийн албан хаагчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд тусгайлан зарим төрлийн зээл (орон сууцны, автомашины гэх мэт зээлээс бусад)-ийн жилийн хүүгийн хэмжээг 36%-иас хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.[23]

Түүнчлэн, Америкийн Нэгдсэн Улсын муж бүр тус тусдаа өөрсдийн иргэдэд тааруулсан хуультай байдаг. Ийнхүү мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулахаар муж тус бүр өөрсдийн гэсэн хүүгийн дээд хэмжээ тогтоосон байдаг байна. Доорх хүснэгтэд АНУ-ын мужуудын хүүгийн дээд хэмжээг харуулсан болно.

№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)	№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)	№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)
1	Алабама	25%	14	Кентакки	2.00%	27	Хойд Каролина	2.00%
2	Аляска	20%	15	Луизиана	10.00%	28	Охайо	5.00%
3	Аризона	8%	16	Майн	25.00%	29	Оклахома	20.00%
4	Калифорни	2.50%	17	Массачусетс	3.00%	30	Орегон	3.00%
5	Коннектикут	3.00%	18	Мичиган	3.00%	31	Пенсильвани	2.50%
6	ДиСи	5.00%	19	Миннесота	3.00%	32	Род Айленд	5.00%
7	Делавэр	3.00%	20	Миссисипи	25.00%	33	Теннесси	2.00%
8	Флорида	25.00%	21	Миссури	2.00%	34	Юта	10.00%
9	Жиоржиа	25.00%	22	Монтана	25.00%	35	Вермонт	3.00%
10	Хавай	10.00%	23	Невада	10.00%	36	Виржиниа	5.00%
11	Иллинойс	3.00%	24	Нью Жерси	4.00%	37	Вашингтон	3.00%
12	Индиана	3.00%	25	Шинэ Мексик	10.00%	38	Висконсин	3.00%
13	Канзас	10.00%	26	Нью Йорк	4.00%	39	Вайоминг	20.00%

Хүснэгт 2. АНУ-ын мужуудын хүүгийн дээд хэмжээ[24]

Мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалтыг хамгаалахын тулд Холбооноос тогтоосон зээлийн хүүг муж нь өөрсдийн хуулийг тогтоохдоо харгалзаж үзэх бөгөөд хэрэв мужийн хууль нь Холбооны хуультай зөрчилдсөн тохиолдол мужийн хуулийг хүчингүй болгодог зохицуулалтай байна. (12 U.S.C.A. § 1 et seq.)

[23] Adam J. Levitin, The New Usury: The Ability-to-Repay Revolution in Consumer Finance, 92 Geo. Wash. L. Rev. 425 (2024).

[24] Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он. 9 дэх тал

Сүүлийн жилүүдэд зээлийн хүүгийн зохицуулалтад өөрчлөлт оруулах чиглэлээр нэлээдгүй шинэчлэл хийсэн бөгөөд "Dodd-Frank" хуулийн хүрээнд хэрэглэгчийн хамгаалалтыг илүү чангатгах, зээлийн картны хүүгийн хязгаарыг тодорхой болгох зорилгоор илүү олон журам гаргасан байдаг.

- Dodd-Frank Wall Street Reform and Consumer Protection Act (2010):

  Энэхүү хуулийн зорилго нь 2008 оны санхүүгийн хямралаас сургамж авч, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, мөн хэрэглэгчийн санхүүгийн эрхийг хамгаалахад чиглэсэн. Энэ хуулийн хүрээнд Consumer Financial Protection Bureau (CFPB) байгууллагыг үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь хэрэглэгчдийн санхүүгийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй агентлаг юм.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд зээлийн хүүгийн зохицуулалт нь олон хууль, тогтоомжид тулгуурласан бөгөөд эдгээр хууль нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мөн банк, санхүүгийн байгууллагуудын шударга үйл ажиллагааг хангахад түлхүү чиглэсэн байна.

4.2.Европын холбооны улсууд

Европын холбооны орнуудад зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон зохицуулалт нь иргэд, бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудын ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байна. Европын холбоо нь өөрийн эрх зүйн тогтолцоонд зээлийн хүүг зохицуулах, зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох талаар олон улсын болон бүс нутгийн хэмжээнд эрх зүйн зохицуулалтыг боловсруулсан.

Мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчныг Европын Холбооны гишүүн орнуудын хүрээнд нарийвчлан авч үзвэл мөнгө хүүлэлтийн талаарх хууль зүйн ухагдахууныг нийт 21 орны эрүү, иргэний холбогдох хууль тогтоомжид тус тус тусгасан байна.

1. Дани, Финлянд, Латви, Румын, Словени, Мальта – Эрүүгийн хуулиар;
2. Эстони, Франц, Унгар, Болгар, Испани – Иргэний хууль тогтоомжоор;
3. Чех, Бельги, Австри, Герман, Грек, Португал, Словак, Польш, Швед, Итали – Эрүү болон иргэний хууль тогтоомждоо тус тус тусгасан байна.[25]

Гишүүн орнууд	Хэрэглээний зээлийн жилийн хүүний дээд хязгаар /APR/	Хүүгийн дундаж хувь хэмжээ	Хамрах хүрээ	Тайлбар
Бельги	10%-19.5%		Бүх зээл	Хамгийн дээд APR нь зээлийн хэмжээ болон төрөл (12 ангилал)-өөс шалтгаалан өөр өөр байдаг. 10% (1250 еврогоос дээш дүнтэй зээл)-аас 19.5% (1250 еврогоос бага дүнтэй зээл) хооронд хэлбэлздэг. Зээлийн нөхцөл нь хүүг ялгавартай тогтоох хүчин зүйл болохгүй.

[25] Улсын Их Хурлын Тамгын Газар. *Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин.* 2017 он. 4-5 дахь тал

Эстони	63.9%		Бүх зээл	Хамгийн дээд APR нь Төв банкнаас тооцож гаргасан дундаж APR (21.3%*3=63.9)-ийн 300%-д хүрдэг. Сар бүр шинэчлэгдэнэ.
Франц	5.72-21.63%	8.12%- 16.6%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь Төв банкнаас 3 сар тутамд зээлийн хэмжээ болон төрөлтэй уялдуулан тооцож гаргасан дундаж APR-ийн 133%-д хүрнэ. Тухайлбал, 5.72% (орон сууцны зээл)-аас 21.63% (1524 евро хүртэлх дүнтэй хэрэглээний зээл) хүртэл хэлбэлзэнэ. Моргейжийн зээлийн хүүгийн дээд хэмжээг тусгайлан тогтооно.
Герман	8.18%-16.4%	4.09%- 8.2%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь зээлийн төрөл, нөхцөлтэй уялдуулан Төв банкнаас тооцож гаргасан дундаж APR-ийн 200%-д хүрнэ. Хэлбэлзэл нь 8.18% (шинэ бизнес; 5-10 жилийн хугацаатай орон сууцны зээл)-аас 16.4% (шинэ бизнес; 5-аас дээш жилийн хугацаатай хэрэглээний зээл) байна. Хүүгийн дээд хэмжээ дундаж APR-ыг 2 дахин нэмэгдүүлэх буюу 12 пунктээс илүүгүй байхаар тогтооно.
Грек	Зарим 6.75%		Зөвхөн ББСБ-ын зээл	Грек улс зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоох систем, засаг захиргааны журмаар 1989 онд хүчингүй болгосон учраас банкны зээлийн хүүд хязгаар тавьдаггүй. Харин банк бус байгууллагын зээлийн хүүг жилийн 6.75%-иас хэтрүүлэхгүй байхаар хязгаарласан.
Ирланд	Зарим 187%		Зөвхөн хадгаламж зээлийн	Зээлийн хоршоодод лиценз олгох үед хүүгийн дээд хязгаарыг зааж өгдөг. Зээлийн нэгдэл,

			хоршоодын зээл	хоршоодын сарын зээлийн хүү 1%-ээс хэтрэхгүй (APR-12.68%)
Итали	4.38%-27.20%	4.38%- 16.97%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь Эдийн засаг, санхүүгийн яамнаас зээлийн төрөл болон хэмжээтэй уялдуулан 3 жил тутамд тооцдог жилийн дундаж APR-ийн 150%-иас хэртэхгүй. 4.38% (моргейжийн зээл)-аас 27.20% (гэр бүлийн бусап зээл)-ийн хооронд хэлбэлздэг. 23 төрлийн хүүгийн дээд хэмжээ тогтоосон.
Мальта	Зарим 8%		Зарим чөлөөлөлт	Бүх төрлийн зээлд хязгаар тогтоосон. Гэхдээ банкуудыг хязгаарлалтаас чөлөөлсөн.
Нидерланд	15%		Моргейж хамаарахгүй. 200 еврогоос бага дүнтэй зээл	Хамгийн дээд APR нь 12% пункт+хуулиар тогтоосон хүү. (Гэрээ зөрчсөн тохиолдолд нэмж төлөх хүүгийн хэмжээ 2010 оны 03 сарын байдлаар 3% байсан). Хүүгийн хэмжээг 6 сар тутамд шинэчлэн тогтооно.
Польш	20%		Бүх зээл	Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь Төв банкнаас тогтоосон ломбардын хүүгийн 400%-тай тэнцүү (5%, сар бүр шинэчлэгддэг) байна. Зээлийн төрөл, хэмжээнээс хамаарахгүй.
Португал	6.7%-31.6%	5.03%- 23.75%		Хамгийн дээд APR нь Төв банкнаас 3 сар тутамд зөвхөн зээлийн төрлөөс хамааруулан тооцож гаргадаг жилийн дундаж APR-ийн 133%-тай тэнцүү байна. 6.7% (барилга, эрүүл мэнд, сэргээгдэх эрчим хүчний зээл)-аас 31.6% (зээлийн карт, зээлийн шугам, харилцах дансны зээл,

				овердафт)-ийн хооронд хэлбэлзэнэ.
Словак	11.52%-79.8%			Хамгийн дээд APR нь тухайн хэрэглээний зээлийн төрлийн жилийн дундаж хүүгийн 200%-иас хэтрэхгүй байхаас гадна нийт хэрэглээний зээлийн төрөл тус бүрийн жигнэсэн дундаж хүүний 400%-иас хэтрэхгүй байна. Зээлийн төрөл, хэмжээ, нөхцөлөөс шалтгаалан 30 төрлийн хүүгийн дээд хэмжээг тооцсон.
Испани	10%		Овердрафт (өөрчилж болно), нийгмийн орон сууцны зээл	Хамгийн дээд APR нь хуулиар тогтоосон хүүг 2.5 дахин нэмэгдүүлсэнээс хэтрэхгүй байна. Нийгмийн дэмжлэгтэй орон сууцны зээлийн хүүг хуулиар тогтоосон хүүгийн түвшнээс хамааруулан индексжүүлж тооцно.
Словени	13.2%-453%	6.6%-226%	Зөвхөн ББСБ-ийн зээл	Хамгийн дээд APR нь зээлийн хэмжээ болон нөхцөлтэй уялдуулан 6 сар тутамд Төв банкнаас тооцож гаргасан жилийн дундаж APR-ийн 200%-иас хэтрэхгүй. 13.2% (120 сар, 20000 евро)-аас 453% (2 сар, 200 евро)-ийн хооронд хэлбэлзэнэ.

Хүснэгт 3. Европын Холбооны гишүүн орнуудын зээлийн хүүгийн дээд хэмжээ (2010 оны 03 сарын байдлаар)[26]

Европын Холбооны гишүүн орнуудын хувьд зээлийн хүүгийн хэмжээг тодорхой байдлаар хязгаарлаж дээд хэмжээг тогтоосон байна. Хүүгийн дээд хэмжээний хувь хэмжээ нь хэлбэлзэл өндөртэй байна. Тухайлбал, Франц Улсын хувьд зээлийн төрлөөс хамаарч хүүгийн дээд хэмжээ 5.72-21.63 хувийн хооронд, Словени Улсад зээлийн хэмжээ болон хугацаанаас хамаарч зээлийн хүүгийн дээд хэмжээ 13.2-453 хувийн хооронд тус тус хэлбэлзэж байна.[27]

Харин санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн хамгаалалтын хувьд Холбооны гишүүн орнууд 2008 онд Европын холбооноос гаргасан 2008/48/EC гэсэн хууль тогтоомж (directive)-оор хэрэглэгчтэй хийж буй зээлийн гэрээнүүдийн гишүүн улс бүрийн

[26] Улсын Их Хурлын Тамгын Газар. *Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин.* 2017 он. 12-13 дахь тал

[27] Улсын Их Хурлын Тамгын Газар. *Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин.* 2017 он. 2 дахь тал

хувьд санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтыг онцгой чухал байдлаар авч үзсэн[28] сайн туршлага байна.

4.3.Япон улс

Япон улсын хувьд 1983 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 32 дугаартай "*Зээлийн үйл ажиллагааны тухай*" хуулийг баталж зээл олгох үйл ажиллагааг зохицуулсан бөгөөд мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "*зээл олгох үйл ажиллагаа гэдэгт дор дурдсан зээл олгохоос бусад байдлаар ашиг олох зорилгоор мөнгө зээлдүүлэх, мөнгө зээлэх эсхүл зээлдүүлэх үйл ажиллагаанд тогтмол зуучлах (мөнгөн зээлийн санхүүгийн хэрэгслийг худалдах замаар мөнгө шилжүүлэх ажиллагаанд зуучлах, барьцааны үл хөдлөх хөрөнгийг худалдах, бусад төсөөтэй үйл ажиллагаа явуулах, аливаа хэлбэрээр мөнгө шилжүүлэх болон хүлээн авах, цаашид хамтад нь "Зээл(нүүд)*" гэх):

(i) Улсын болон орон нутгийн төрийн байгууллагаас олгосон зээл;
(ii) Бусад хуулийн зохицуулалтаар тогтмол зээл олгодог этгээдээс олгосон зээл;
(iii) Бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагаа явуулдаг этгээдээс олгосон зээл эсхүл бараа бүтээгдэхүүн худалдах болон худалдан авах үйл ажиллагаанд зуучлагчаар оролцдог этгээдээс тэдний төлбөрийн шилжүүлгийн явцад олгогдсон зээл;
(iv) Ажил олгогчоос ажилтанд олгосон зээл; болон
(v) Дээр дурдсанаас гадна, санхүүжилт хүссэн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулахгүйгээр Засгийн газрын эрх бүхий этгээдүүдээс олгосон зээлнүүд.[29]

Түүнчлэн, 1954 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар "*Зээлийн хүүгийн түвшинг хязгаарлах тухай*" хуулиар дараах дээд хэмжээг хуульчилсан байна. Үүнд:

- 100,000 иенээс бага үнийн дүн бүхий зээлийн хувьд жилийн 20 хувиас хэтрэхгүй;
- 100,000 иенээс 1,000,000 иенийн хооронд үнийн дүн бүхий зээлийн хувьд жилийн 18 хувиас хэтрэхгүй;
- 1,000,000 иен болон түүнээс их үнийн дүн бүхий зээлийн хувьд жилийн 15 хувиас хэтрэхгүй бөгөөд энд заасан харгалзах хэмжээнээс өндрөөр тогтоосон тохиолдолд хүчин төгөлдөр бус байхаар зохицуулжээ.[30]

Түүнчлэн, 1954 оны 195 дугаартай "*Хандив хүлээн авах, мөнгө хүлээн авах болон хүүгийн хэмжээ зохицуулах тухай"* хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу жилийн 20 хувиас өндөр хүүтэйгээр зээл олгосон бөгөөд тухайн зээлийн хүүг төлөхийг албадан шаардсан тохиолдолд албадан ажил хийлгэх нөхцөл бүхий хорих газарт 5 хүртэл жилийн хугацаатай ял шийтгэх, 10,000,000 иен хүртэл хэмжээгээр мөнгөн торгууль ногдуулах эсхүл аль аль шийтгэлийг ногдуулах эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.[31]

Мөн зээлийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь хураамж авах гэрээ байгуулах ёсгүй, зуучлалд заасан мөнгөн дүнгийн 5 хувиас давсан шимтгэлийг авах ёсгүй байна. Бүх нэмэлт төлбөрийг оруулаад дээд тал нь 20 хувь байна хэмээн тусгажээ.[32]

---

[28] Монголбанк.*Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд.* 27 дахь тал
[29] Money lending business act. 1983. Article 2.1.
[30] Interest Rate Restriction Act. 1954. Article 1.
[31] Act Regulating the Receipt of Contributions, the Receipt of Deposits, and Interest Rates. 1954. Article 5.
[32] Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он. 7 дахь тал

Япон Улсын хувьд анх зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохдоо 109.5 хувиар тогтоож, дараа нь 40 хувь болгон бууруулж, дараа нь дахин 29.2 хувь болгон бууруулж байсан.[33]

Ийнхүү зээлийн хүүгийн хэмжээг бууруулан тогтоосон нь Япон Улсад 2000-аад оны эхэн үеэр дэлгэрсэн хууль бус зээлийн үйл ажиллагаанд шууд нөлөөлсөн гэх баримт байдаггүй[34] бөгөөд хууль бус зээлийн үйл ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж буй зээл олголтын нэгэн адил илт буурсан үзүүлэлттэй байсан.[35]

Түүнчлэн, Япон Улсын Цагдаагийн Ерөнхий Газраас 2011 оны эхний хагасын байдлаар өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад мөнгө хүүлэлтийн гэмт хэргийн хохирогчийн тоо 25 хувиар буурсан үзүүлэлттэй байсан бөгөөд 2012 оны 4 дүгээр сард Япон Улсын Ерөнхий сайдын зүгээс Зээлийн үйл ажиллагааны тухай хууль нь хууль бус зээлийн үйл ажиллагааг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн[36] гэдгийг албан ёсоор онцлон тэмдэглэсэн байна.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай улсын хувьд банк, санхүүгийн салбар өргөжин тэлж, эдийн засагт томоохон байр суурь эзэлж байгаатай зэрэгцэн санхүүгийн салбарын хэрэглэгчдийг хамгаалах, тэднийг хэт өрийн дарамтанд орохоос сэргийлэх болон өндөр зардал бүхий зээлийн үйл ажиллагааг хумих шаардлага тулгараад байгаа билээ.

Хэдийгээр Монгол Улсын хувьд 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, барьцаалан зээлдүүлэх газар болон иргэд хоорондын өндөр хүүтэй зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон байх боловч банк, санхүүгийн байгууллагаас олгож буй зээлийн хүүгийн хэмжээнд аливаа хязгаарлалт тавих эрх зүйн үндсийг бүрдүүлээгүй байна.

Өөрөөр хэлбэл, олон улсын туршлагаас харахад мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалт нь зөвхөн зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохоос гадна санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн эмзэг хэсэгт санхүүгийн хүртээмжийг сайжруулах, өндөр өртөг бүхий зээлийн үйлчилгээг бууруулах, мөнгө хүүлэх үйл ажиллагааг тодорхойлох, хариуцлага хяналтын механизмыг оновчтой тодорхойлох зэрэг нийгэм, эдийн засгийн цогц шийдэл шаардлагатай асуудал байна.

Харин манай улсын хувьд 2018 онд “*Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль*”-ийн төслийг санаачлан боловсруулсан боловч тус хуулийн төсөл нь бодитой судалгаанд суурилаагүй, бусад хууль тогтоомж болон эдийн засгийн зохицуулалтын механизмуудтай хэрхэн уялдаж хэрэгжих нь тодорхойгүй байсан зэрэг шалтгаанаас үүдэн дэмжигдээгүй байна. Үүний дараа Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “*Зээлийн хүүг бууруулах стратеги*” баталж, дараах 4 үндсэн чиглэлийг тодорхойлж, 2023 оны эцэст зээлийн хүүг 1 хувьд хүргэх зорилт тавьсан боловч харамсалтай нь хэрэгжээгүй байна.

Энэ нь цаашид зээлийн хүүг бууруулахад зөвхөн хөтөлбөр, чиглэл батлах нь хангалтгүй болохыг харуулж байна. Иймд бид энэхүү судалгааны үр дүнд дараах санал, зөвлөмжийг боловсруулласа. Үүнд:

1. Дэлхийн банкнаас зээлийн хүүний зохицуулалтыг хийхдээ санал болгодог дараах 3 чиглэлийг зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохдоо баримтлах. Үүнд:

[33] Naoki Kanayama. *Struggles against Usurious Loans in Japan*. 2012. Page 64.

[34] Centre for responsible credit. Taking on the money lenders: Lessons from Japan. 2012. Page 20.

[35] Мөн тэнд.

[36] Мөн тэнд.

(i) зах зээлийн өрсөлдөөнийг сайжруулах замаар хүүгийн хэмжээг бууруулах;
(ii) өрийн дарамтанд орох өндөр эрсдэл бүхий нийгмийн бүлгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах; болон
(iii) санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, санхүүгийн мэдээллийг хүртээмжтэй байлгах.[37]

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч үр дүнгээ өгөөгүй нөхцөлд зээлийн хүүг тодорхой түвшинд хязгаарлах талаар нийгэм, эдийн засгийн цогц судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах;[38]

2. Санхүүгийн хэрэглэгч гэсэн ойлголтыг тодорхойлж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах;

3. Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоохдоо олон улсын туршлагад суурилж, хэт өндрөөр эсвэл хэт багаар тогтоосноос үүдэн нийгэм эдийн засагт гарсан сөрөг үр дагаваруудыг харгалзан, оновчтой тогтоох;

4. Зээлийн хүүгийн дээд хязгаарыг зөрчиж зээл олгох үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг тодорхойлох; болон

5. Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох субъект болон хяналт тавих субъектийг оновчтой тодорхойлох тус тус шаардлагатай гэж үзэж байна.

VI. ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын хууль тогтоомжууд

(i) Иргэний хууль (2002 он)
(ii) Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль (2022 он)
(iii) Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл

2. Гадаад улсын хууль тогтоомжууд

(i) Interest rate restriction act of Japan (1954)
(ii) Moneylending business act of Japan (1983)
(iii) Act Regulating the Receipt of Contributions, the Receipt of Deposits, and Interest Rates (1954)
(iv) Dodd-Frank Wall Street Reform and Consumer Protection Act (2010)
(v) National Bank Act (1863)
(vi) Federal Deposit Insurance Act (1933)
(vii) National Credit Union Administration Act (1970)
(viii) Military Lending Act (2006)

3. Нийтлэл, өгүүлэл, судалгаа, илтгэлүүд (Монгол хэлээр)

[37] CGAP.*Interest Rate Ceilings and Microfinance: The story so far.* 2004. Page 11-13 https://documents1.worldbank.org/curated/en/572411468139208387/pdf/334790rev0ENGLISH0OccasionalPaper19.pdf?utm_source=chatgpt.com Хамгийн сүүлд 2025 оны 2 дугаар сарын 7-ны өдөр хандсан

(i) Эрдэнэ.С. *Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэллтэй тэмцэх тухай хуулийн төсөл.* 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр. https://forum.parliament.mn/projects/295
(ii) Эдийн засгийн байнгын хороо. *Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл бариmтлал, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаархи санал, дүгнэлт.* 2018 он. file:///C:/Users/Owner/Downloads/%D0%B7%D1%8D%D1%8D%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%85%D2%AF%D2%AF-%D1%85%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB%D1%86%D1%8D%D1%85%20%D1%8D%D1%81%D1%8D%D1%85%20(3).pdf
(iii) Монголбанк. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэнцэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монголбанкнаас гаргасан зөвлөмж. //,* Мөнгө, санүү, баялаг сэтгүүл, (2019, №14)
(iv) Дэлхийн банк. *Монголын эдийн засгийн тойм. Эдийн засгийн тогтвортой байдал, банкны зээлийн өсөлт.* 2020 оны 1 дүгээр сар. https://documents1.worldbank.org/curated/zh/990641581913444305/pdf/Mongolia-Economic-Update-Macroeconomic-Stability-and-Credit-Growth.pdf
(v) Дэлхийн банк *Монголын эдийн засгийн тойм.* 2024 оны 11 дүгээр сар. https://documents1.worldbank.org/curated/en/099533111272490277/pdf/IDU17bc4d9961fbf71470b19731126d994aab926.pdf
(vi) Монголбанк.*Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд*
(vii) Улсын Их Хурлын Тамгын Газар. *Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин.* 2017 он
(viii) *Монголбанк. Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа. 2022 он*
(ix) Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он
(x) Батзориг.Г. *Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох нь боловсон цэвэрлэгээ гэж үү?*. //, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, (2019, №15)
(xi) Санхүүгийн зохицуулах хороо. *Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь.* 2023 он

4. Нийтлэл, өгүүлэл, судалгаа, илтгэлүүд (Англи хэлээр)

(i) Garner, B.A.(Ed). (2014). Black's law dictionary (10th ed.). ///. United States of America: Thompson Reuters. P.1778
(ii) World Bank Group, (2014). Interest Rate Caps around the World. https://documents1.worldbank.org/curated/en/876751468149083943/pdf/WPS7070.pdf Last visited on 6 February 2025
(iii) IFC Secretariat. (2022). Guidance note 2 – Interest Rate Policy and Anti-Usury Regulations. https://www.bis.org/ifc/interest_rate_policy.pdf Last visited on 6 February 2025
(iv) Naoki Kanayama. *Struggles against Usurious Loans in Japan.* 2012
(v) Centre for responsible credit. Taking on the money lenders: Lessons from Japan. 2012
(vi) CGAP.*Interest Rate Ceilings and Microfinance: The story so far.* 2004. Page 11-13 https://documents1.worldbank.org/curated/en/572411468139208387/pdf/334790rev0ENGLISH0OccasionalPaper19.pdf?utm_source=chatgpt.com